



ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ОХУ-ЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА В.В. ГЕРАСИМОВ БХЯ, ЗХЖШ-Т АЙЛЧЛАВ



ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В. Герасимов өчигдөр Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд тус бүрэлдэхүүн ЗХЖШ-д ажиллаж ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д. Ганзориг ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В. Герасимовтой хэлэлцээ хийсэн юм. Хэлэлцээрийн дараа Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр төлөөлөгчдийг БХЯ-нд хүлээн авч уулзаж, санал солилцов. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ой тохиож буй энэ цаг үед таны айлчлал болж байгаагаараа их онцлогтой байна. Орос Улс бол Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрч, дэмжин дипломат харилцаа тогтоосон анхны улс билээ. Энэ удаагийн айлчлал манай цэргийн хамтын ажиллагаанд түлхэц өгнө гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын Засгийн газар "2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлэх" зорилгыг тусгаж, Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Бид Зэвсэгт хүчнийхээ зэвсэглэл, техникийг шинэчлэх зорилгыг ОХУ-тай тогтоосон цэрэг-техникийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх бодлогыг цаашид ч тууштай баримтлах болно. Хоёр улсын батлан хамгаалахын харилцаа, хамтын ажиллагаа тогтсон уламжлалаар цаашид үргэлжлэн амжилттай өргөжин хөгжинө гэдэгт итгэлтэй байна" хэмээн онцлон тэмдэглэсэн юм.

Талууд хоёр орны цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны өргөн хүрээний асуудлаар

санал солилцож, хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны өнөөгийн явцыг дүгнэж, харилцааны хөгжлийн цаашдын төлөвлөлтийн талаар, тэр дундаа ойрын хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй ярилцсан юм. Мөн ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, ОХУ-ын баатар, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В. Герасимов цартахлын хүнд хэцүү цаг үеийг үл харгалзан төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгааг онцлоод олон улсын цэргийн наадмын хүрээнд Монгол Улсын нутагт уламжлалт "Аравт" морин марафон, "Цэргийн ралли" тэмцээнүүдийн гуравдугаар шатыг зохион байгуулагдана гэдэгт найдаж буйгаа илэрхийлэв.

Үдээс хойш айлчлалын бүрэлдэхүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхэд бараалсан юм. Энэ хүрээнд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол, Оросын ард түмэн дайны хүнд үе, энх цагийн бүтээн байгуулалтад хамтдаа байж ирснийг тэмдэглэв. Жанжин штабын даргын айлчлал хоёр орны батлан хамгаалах салбар, тэр дундаа Зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагаанд чухал түлхэц өгнө гэдэгт итгэлтэй байгааг хэлэв. Үүний хариуд харилцаа, хамтын ажиллагаанд сэтгэл хангалуун байдгаа ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В. Герасимов илэрхийлсэн юм. Тухайлбал Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдыг цэргийн академи, их, дээд сургуульд сургаж бэлтгэхийн зэрэгцээ жил бүр "Сэлэнгэ" байлдааны буудлагатай хамтарсан хээрийн сургууль зохион байгуулдгийг хэлэв. Уулзалтын үеэр хоёр орны цэрэг, цэрэг-техникийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр санал солилцлоо.



Түүхэнд энэ өдөр

1911 он. Их Хүрээг чөлөөлж, Хаант Монгол улстусгаартогтнолоозарлав.

1914 он. М.Доржпалам Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны сайдаар томилогдов.

1933 он. Улсыг Хамгаалах Зөвлөлийг өөрчлөн СнЗ-ийн дэргэд Улсыг Хамгаалах Комиссыг байгуулжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-7	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,220.0	3,235.0
CNY	446.3	447.0
RUB	37.80	39.20
JPY	24.84	25.44
KRW	2.37	2.46

ЗУРХАЙ

2021.12.01 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 27/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.21-17.02

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал:

Хий

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

Үс засуулбал ӨЛЗИЙТЭЙ сайн

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
371.202 +190

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,922 +8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6524 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
101

ЭДГЭРСЭН
6298

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 263,013,650

Эдгэрсэн
Нийт: 237,494,861

Нас барсан
Нийт: 5,232,579



цаг үе, үйл явдал

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫНХАН ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



ёстой. Түвшин тогтоох үзлэгээр Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлага гээд олон зүйлийг нэгтгэн гаргаж, анхаарч ажиллах асуудлын гогцоог гаргах нь дамжиггүй. Удахгүй бид нэгдсэн дүгнэлтээ гаргаж, танилцуулна” гээд командлалын бүрэлдэхүүнд амжилт хүссэн юм.

Түвшин тогтоох үзлэгийн төгсгөлд Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар

Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг амжилттай явагдсаар байна. Өнгөрсөн тавдугаар сараас эхэлсэн тус түвшин тогтоох үзлэгт одоогоор Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалууд, нэгтгэл, ангиуд болон Батлан хамгаалах яамны харьяа 10 гаруй байгууллагын бүрэлдэхүүн бүрэн хамрагдаад байна. ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямбаар ахлуулсан комиссын бүрэлдэхүүн 11 дүгээр сарын 29-ний өдөр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчид ажиллаж, офицер, ахлагч бүрийн бие тамирын бэлтгэлжилт, ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн байдлыг тогтоохоор таван чиглэлийн шалгалт авсан юм.

Бие тамирын бэлтгэлжилтийг дүгнэхийн өмнө ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба үзлэг зохион байгуулан явуулж байгаа



ажлын хэсгийнхний танилцуулаад офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэхэд үзлэгийн зорилго чиглэгдэж байгааг онцлов. Тэрээр үргэлжлүүлэн “Энэ бол уралдаан тэмцээн биш ч гэсэн та өөрийгөө бүрэн дайчлан үзлэгтээ хамрагдах

комиссын бүрэлдэхүүнд талархал илэрхийлээд, амжилт хүслээ.

Ташрамд дурдахад, офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хэмжээнд 99 хувьтай явагдаж байгаа ба маргааш буюу 12 дугаар сарын 01-ний өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын бүрэлдэхүүн бүрэн хамрагдана. Харин БХЯ-ны хувьд комиссын бүрэлдэхүүнээ сонгож, үзлэгийг дотооддоо явуулснаар энэхүү арга хэмжээ дуусгавар болж байгаа юм. Нэгдсэн дүгнэлтийг ирэх оноос өмнө гаргах ажээ.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАТАЙ ХАМТРАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар анги Зэвсэгт хүчний Авто тээврийн хяналтын албатай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ангийн нийт

бие бүрэлдэхүүнд Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгууллаа. Сургалтыг Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албаны урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах

мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Д.Ганхуяг лекц болон харилцан ярилцах хэлбэрээр зохион байгуулж бие бүрэлдэхүүний асуултад тодорхой хариулт өгсөн чанартай сургалт боллоо.

30КМ-ИЙН МАРШИЙГ ЯВУУЛАВ



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

2021-2022 оны сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу энэ сарын 30 км-ийн маршийг төлөвлөн Налайх-Майхан уул-Найман шарга-Бүс

нуур-Зэвсэгт хүчний 337 дугаар анги-Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн байрлал гэсэн маршрутаар маршийг зохион байгууллаа.

Маршийн замд хичээлийг байр зүйн баримжаалал, амьд гарах арга гэсэн хоёр цэгт зохион

байгуулан явуулсан юм. Мөн өчигдөр сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Хужирбулан дахь буудлагын төвд буудлагын анхны дасгалыг боловсрууллаа.

ЦЭЦЭН БУУГАА МӨРЛӨСӨН ЦЭРЭГ ЭРС ЖАВХААТАЙ БАЙНА



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Зэвсэгт хүчиндээ 2021 оны намар хугацаат цэргийн алба хаахаар ирсэн залуус өнөөдөр хөөрч баярлаад тун завгүй өнжиж байна. Маргааш буюу 11 дүгээр сарын 25-ны өдөр Монгол цэргийн сүр хүч, тэмцэл ялалтын билгэдэл болсон аранзал улаан тугийн дор цэцэн буугаа мөрлөсөн цэрэг эрс жигдрэн жагсахаар бэлтгэлээ эцэслэн базааж байгаа нь энэ. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги бүрд эх орныхоо дуудлагаар ирсэн олон мянган залуус өнгөрсөн 10 дугаар сараас хойш цэргийн албаны анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, эх орондоо үнэнчир баталгаа болсон Цэргийн тангаргаа өргөх гэж байна.

бэлтгэл, сэтгэл зүй, ёс зүй, хууль эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, галын бэлтгэл гэсэн хичээлээр амжилттай зохион байгуулж явуулжээ. Сургалт, бэлтгэлийг ангийн захирагчийн баталсан “Долоо хоногийн товч”, “Өдөр тутмын цагийн хуваарь”-ийн дагуу өдрийн 10 цаг онол болон дадлагын хэлбэрээр явуулсан байна.

“Бидний сургалт бэлтгэлийн ач холбогдол нь шинээр ирээд удаагүй байгаа дайчдад цэргийн хэргийн анхан шатны мэдлэгийг зөв олгож, ангийн дотоод журам, өдөр тутмын цагийн хуваарь, долоо хоногийн товчийг танилцуулж, Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүдэд

заагдсан дүрэм журам, эрх, үүргийг ойлгуулан таниулах, цэргийн алба хаагчдын хоорондын харилцаа, ёсолж хүндлэх, алхаж гишгэх, галт хэрэглэлтэй харьцах талаар цогц ойлголт өгөхөд оршиж байна” гэж тэрээр нэмж тодотголоо.

Энэ жил Сургалтын төвд үүрэг гүйцэтгэж буй салааны захирагч, салааны ахлагч нарын хувьд 2-3 жилээс дээш хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн дагуу харьцаж, хичээл сургалтыг чанартай зохион явуулж ирсэн дадлага туршлагатай цэргийн алба хаагчид ажээ.

Шинээр ирсэн дайчид сэтгэл зүй болоод ёс зүйн хувьд харьцангуй төлөвшсөн,



тогтвортой, цэргийн алба хаах хүсэл эрмэлзэл дүүрэн байгаа нь цэргийн албанд хурдан дасах, цэргийн хэргийн мэдлэгийг богино хугацаанд чанартай олж авахад сайнаар нөлөөлсөн байна.

Цэргийн тангаргийг чанга дуугаар байн байн унших байлдагч Б.Одгэрэлийн сэтгэгдлийг хуваалцахад “Байлдааны гавьяаны Улаан тугийн болон Алтан гадас одонт, БНМАУ-ын маршал Г.Дэмидийн нэрэмжит Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат цэргийн алба хаах болсондоо бахархалтай байна. Цэрэгт ирээд олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн цэргийн албаны бүх зүйлсийг цагийн хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, эртэч, хурдан шаламгай, цэвэрч

нямбай, өөрийгөө бус нөхдөө бодох зан, бүгдийг хамтдаа хийх, эр хүний гэсвэр хатуужилтай зан чанар, аливаа зүйлсийг эергээр харах, улс орныхоо тусгаар тогтнолын үнэ цэн, эх орноо хайрлан хамгаалах сэтгэлтэй болж төлөвшиж байгаадаа маш их баяртай. Энэ бол миний насан туршийн минь бахархал. Амьдралын минь зам мөрийг тэгшлэх зан харилцаа, хандлагыг би энэ цэргийн албанаас авч байгаадаа талархаад баршгүй” хэмээсэн нь сонсож зогсоо надад ямар сайхан сэтгэгдэл төрүүлж байсан гэвч. Зэвсэгт хүчний ирээдүй өдрөөс өдөрт гэрэлтэж байна...

Ахлах дэслэгч Г.ЭРДЭНЭБАТ



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)